

## 1. Орон нутаг дахь анхны сургалт семинар зохион байгуулагдлаа

10-р сарын 3-6-ны хооронд DPUB2 төслийн багийнхан Дархан-Уул аймаг /цаашид Дархан гэх/-г очиж, ААНБ, төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын нийт 60 гаруй оролцогчдод “Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны сургалт-ААНБ-ын нөлөөллийн семинар”-ыг зохион явууллаа.

Төслийн багийнхан Дархан-Уул аймагт 10-р сарын 3-ны өдөр очиж аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төвийн дарга С. Энхболдтой уулзаж, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудлын талаар ярилцав. 10-р сарын 4,5-ны өдрүүдэд, “Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны сургалт-Байгууллагын нөлөөллийн семинар”-ыг зохион байгуулж, “Хөгжлийн бэрхшээл ба нийгмийн загвар”, “Ажлын байрны дадлагажуулагчийн үүрэг ба үндсэн үйл ажиллагаа”, “Ажлын байрны дадлагажуулагчийн дэмжин туслах үйлчилгээг хэрхэн ашиглах тухай”, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо”, “ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн жишээ ба ажлын байрны орчин нөхцлийг цогцоор нь шийдэх арга зам” зэрэг сэдвээр илтгэл танилцуулав.

Тус аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй “Тэргэнцэртэй иргэдийн холбоо” болон “Хараагүйчүүдийн холбоо”, “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн холбоо”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо” зэрэг байгууллагын төлөөлөл болон бусад байгууллагын төлөөллийн зүгээс, аймаг орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү олноор хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, ААНБ-д нөлөөлөх нөлөөллийн ажлыг идэвхтэй үргэлжлүүлэхийн зэрэгцээ, ирээдүйд ажлын байрны дадлагажуулагчаар ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.



Дархан-Уул аймгийн томилолт: Семинарын дараа

## СЭДЭВ

1 Орон нутаг дахь анхны сургалт семинар зохион байгуулагдлаа

2 Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажилладаг Ч.Пүрэвхүүтэй танилцана уу

3 DPUB2 төсөл ААНБ дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 3 дахь удаагийн семинар зохион байгууллаа

## 2. Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажилладаг Ч.Пүрэвхүүтэй танилцана уу

DPUB2 төсөл Дархан-Уул аймагт ажиллах хугацаандаа тус аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй залуутай танилцсан юм.

Түүнийг Чулуун-Эрдэнэ овогтой Пүрэвхүү гэдэг. Тэрээр арван хоёр жилийн өмнө автомашины осолд орж нуруу нугасандаа гэмтэл авч одоо тэргэнцэр хэрэглэдэг. Ч. Пүрэвхүү нь Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажилладаг. Тэрээр 2018-2020 оны хооронд Засгийн газрын мөрийн хөтөлбөр болох Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт ажиллаж байгаад, 2020-2021 онд ХБИ-ийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, 2021 оны 5 сараас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон тохируулгатай ажлын байрыг бий болгож зөвлөгөө мэдээлэл хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна.

Түүний өдөр бүрийн ажил төрийн үйлчилгээг авахаар ирсэн иргэдийг хамгийн түрүүнд угтан, хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ зэрэг байгууллагаас үзүүлдэг бүхий л зөвлөгөө, мэдээллийг өгөхөөс эхэлдэг. Ажлын байрны тохируулгад хэвлэх машиныг хажууд нь байрлуулжээ. Үйлчлүүлэхээр ирсэн иргэнтэй холбоотой мэдээллийг нээлтэй харуулах компьютер тавьж дэлгэцийг үйлчлүүлэгчийн талруу харуулсан байна. Сонсголын бэрхшээлтэй хүн үйлчлүүлэхээр ирсэн тохиолдолд дохионы хэлмэртэй онлайнгаар шууд холбогдох тоног төхөөрөмжийг ч байршуулсан байна. Орж гарах налуу зам, бие засах өрөө зэрэг тэргэнцэртэй хүн саадгүй ажиллах боломжит тохируулгуудыг бүрдүүлж өгчээ.

Пүрэвхүүтэй түүний өдөр тутмын амьдрал, ажлын талаар богинохон хугацаанд ярилцаж байхад тус аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хамт олон болон С. Энхболд дарга ихэд дэмжин ажилладаг нь Пүрэвхүүгийн ярианаас тод байлаа.



Ч. Пүрэвхүү Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга С. Энхболдын хамт

### 3. DPUB2 төсөл ААНБ дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 3 дахь удаагийн семинар зохион байгууллаа

DPUB2 төслийн үйл ажиллагааны нэг ААНБ дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 3 дахь удаагийн семинарыг 10-р сарын 13-нд Монгол-Япон төвд зохион байгууллаа. Тус семинарт 25 ААНБ-уудын 28 оролцогчид оролцож Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс үзүүлж байгаа дэмжлэг, ажлын байрны тохируулга, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээ, ААНБ-уудын үүрэг, хариуцлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд ААНБ, төр, төрийн бусын хамтын ажиллагааг бий болгох гэсэн сэдвээр мэдээлэл авсан юм. Өнгөрсөн 4-р сард Мираиро компанийн мэргэжилтнүүд Монгол улс дахь ААНБ-уудад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих семинарыг удирдан зааж байсан бол энэ удаагийн семинарыг нөлөөллийн багийн гишүүдтэй хамтран удирдан явууллаа.

Үдээс өмнө нөлөөллийн багийн гишүүн Х. Батчимэг “Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн нөхцөл байдал, Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар” гэсэн сэдвээр лекцээ танилцууллаа.



Семинарын оролцогчид дасгал ажил ажиллаж байна

Дараа нь нөлөөллийн багийн гишүүн Х. Мөнхтуул “Монгол улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээ, Тохирох хэрэглэгдэхүүнийг бий болгох аргачлал-Тэгш хамруулсан ажлын байрны орчин” сэдвээр танилцуулсан юм.

Үдээс хойш Мираиро компанийн мэргэжилтнүүд “ХБИ-ийн нийгмийн оролцоог хангах чиглэлээр Японы ААНБ-уудын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх дэлхий нийтийн чиг хандлага” сэдвийг танилцуулав. ЖАЙКА-ын мэргэжилтнүүд илтгэл тавьсаны дараа ААНБ-уудын хамгийн их сонирохдог сэдэв болох “Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р зүйл дэх ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, ажил олголтын квот, ажлын байрны төлбөр, урамшуулал” гэсэн сэдвээр нөлөөллийн багийн гишүүн Д. Удвал мэдээлэл, танилцуулга өгч оролцогчдтой санал бодлоо солилцлоо.

DPUB2 төсөл ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ААНБ-уудтай хамтран ажиллах болно. Семинарт оролцсон ААНБ-уудын төлөөлөл ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар багагүй ойлголттой болж цаашид хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байлаа.



ЛСА-ийн мэргэжилтнүүд семинарт оролцогчидод өөрсдийгөө танилцуулж байна



[dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160



<https://www.facebook.com/jicadpub1and2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

